



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар АА71

Булган сум

Аймгийн аюулгүйн нөөцөд өвс
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 28 дугаар "Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 178/2024 дүгээр "Аймгийн нөөцөд өвс нийлүүлэх ажил"-ын гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Өвсний нөөц бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Мөнх тунгалаг тамир" хоршооны нийлүүлэх 11250 боодол өвсийг гэрээнд туссан байршилд хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)
Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын ахлах
мэргэжилтэн)
М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй"
ОНӨХХК-ийн захирал)

2. Аймгийн аюулгүйн нөөцөд техникийн шаардлага хангасан өвсийг хүлээн авч, хадгалалт, хуваарилалтыг хариуцаж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (М.Лхагваням)-д, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т тус тус үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, баримт материал бүрдүүлж ажиллахыг Ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Булган сум 2024 өдөр бүр Дос/2024/Захирамж

6324011138